ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Хөдөлмөрийн яамны захиргааны статистик мэдээгээр дүүргийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо нийслэл хотод 2014 оны 12 дугаар сарын эцэст 15787 болж, өмнөх оны мөн үеэс 11.6 хувь буюу 1644 хүнээр өсчээ. Нийт ажилгүйчүүдийн 8772 буюу 55.6 хувь нь эмэгтэйчүүд байна.

2014 оны 12-р сард ажилгүй 3402 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй ажилгүй байсан 649 иргэн ажилд зуучлагдан орж, 2526 иргэн бүртгэлээс хасагджээ.

Хүснэгт 28. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо, насны бүлгээр, бүгд, 12-р сарын эцэст

Насны бүлэг	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он
16-24	2095	6306	3354	5631	4325
25-34	2962	10011	4543	4059	6012
35-44	2111	7460	2809	2294	2889
45-аас дээш	1920	5554	2105	2159	2561
Ажилгүй иргэд /нийслэл/	9088	29331	12811	14143	15787
Ажилгүй иргэд /улсын дүн/	38250	57171	35776	42772	36970
Улсын дүнд эзлэх хувь	23.8	51.3	35.8	33.1	42.7

Насны бүлгээр авч үзвэл нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 27.4 хувь буюу 4325 нь 15-24 насны, 38.1 хувь буюу 6012 нь 25-34 насны, 18.3 хувь буюу 2889 нь 35-44 насны, 16.2 хувь буюу 2561 нь 45-аас дээш насны хүмүүс байна.

Хүснэгт 29. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо, насны бүлгээр, эмэгтэй, 12-р сарын эцэст

Насны бүлэг	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он
16-24	906	2875	1836	3201	2571
25-34	1487	3911	2540	2276	3509
35-44	1124	3232	1498	1280	1518
45-аас дээш	971	2766	1006	1059	1174
Ажилгүй иргэд /нийслэл/	4488	12784	6880	7816	8772
Ажилгүй иргэд /улсын дүн/	20116	26043	18766	23470	20459
Улсын дүнд эзлэх хувь	22.3	49.1	36.7	33.3	42.9

2014 онд 46360 хүн дүүргийн хөдөлмөрийн хэлтэст ажилд орохоор шинээр бүртгүүлсэн нь өмнөх оноос 16.9 хувь буюу 6697 хүнээр өсчээ. 2014 онд 9872 хүн хөдөлмөрийн хэлтсээр зуучлуулан ажилд орсны 3.0 хувь нь улсын үйлдвэрийн газарт, 7.8 хувь нь төрийн төсөвт байгууллагад, 89.2 хувь нь компани, нөхөрлөл, хоршоо болон бусад газарт ажилд оржээ.

Хүснэгт 30. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо, дүүргээр, 12-р сарын эцэст

Дүүрэг	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он
Бүртгэлтэй ажилгүй иргэд, бүгд	9088	29331	12811	14143	15787
Багануур	754	1616	357	311	418
Багахангай	434	265	173	77	126
Баянгол	868	3689	1854	2426	2489
Баянзүрх	1164	5742	1446	2670	3290
Налайх	219	1515	1395	1266	1093
Сонгинохайрхан	2289	6951	2227	2619	2197
Сүхбаатар	543	2461	2729	1635	1925
Хан-Уул	600	1745	919	1027	1964
Чингэлтэй	2217	5347	1711	2112	2285

Зураг 24. Дүүргийн ажилгүйчүүд, УБ хотын дүнд эзлэх хувь



Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 20.8 хувь буюу 3290 нь Баянзүрх, 15.8 хувь буюу 2489 нь Баянгол, 14.5 хувь буюу 2285 нь Чингэлтэй, 13.9 хувь буюу 2197 нь Сонгинохайрхан, 12.4 хувь буюу 1964 нь Хан-Уул, 12.2 хувь буюу 1925 нь Сүхбаатар, 6.9 хувь буюу 1093 нь Налайх, 2.7 хувь буюу 418 нь Багануур, 0.8 хувь буюу 126 нь Багахангай дүүрэгт тус тус амьдарч байна.

Хүснэгт 31. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр /1-р сарын 1-ний байдлаар/

	Ажилгүйчүүдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2013 он	2014 он	2015 он	2013 он	2014 он	2015 он
Нийт ажилгүйчүүд	12811	14143	15787	100	100	100
Үүнээс: дээд боловсролтой	5041	5800	6422	39.3	41.0	40.7
Тусгай дунд боловсролтой	950	1423	1071	7.4	10.1	6.8
Мэргэжлийн анхан шатны Боловсролтой	918	750	851	7.2	5.3	5.4
Ерөнхий боловсролтой	5836	6125	7361	45.6	43.3	46.6
Мэргэжилгүй	66	45	82	0.5	0.3	0.5



ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2014 онд 41786 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оноос 1599 хүүхдээр олон байна.

Нийт төрсөн хүүхдийн 14.2 хувь буюу 5932 нь бусад аймгийн харьяат эхчүүдээс төрсөн байна.

Хүснэгт 32. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл

	2012 он	2013 он	2014 он	$\frac{2014}{2013}$ %
Амаржсан эхийн тоо	37024	39906	41427	103.8
Амьд төрсөн хүүхэд	37214	40187	41786	104.0
Эхийн эндэгдэл	16	21	15	71.4
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	486	546	625	114.5
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	13.05	13.59	14.96	110.1

Нялхсын эндэгдлийн 26.6 хувь буюу 117 нь Сонгинохайрхан, 23.2 хувь буюу 102 нь Баянзүрх, 12.7 хувь буюу 56 нь Баянгол, 12.1 хувь буюу 53 нь Чингэлтэй, 10.2 хувь буюу 45 нь Хан-Уул, 8.6 хувь буюу 38 нь Сүхбаатар, 3.4 хувь буюу 15 нь Налайх, 2.7 хувь буюу 12 нь Багануур, 0.5 хувь буюу 2 нь Багахангай дүүрэгт тус тус гарсан байна.

Нялхсын эндэгдлийн 28.6 хувь буюу 179 нь бусад аймгийн харьяат байна. Өмнөх оноос нялхсын эндэгдэл 1.37 промилээр өсчээ.

Нийслэлд 2014 онд 17610 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оноос 4.3 хувь буюу 795 хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 10.04 продицилээр тус тус буурчээ.

Зураг 25. Халдварт өвчнөөр өвчлөгсөд, сараар



Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 20.5 хувийг тэмбүү, 14.4 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 13.1 хувийг салхинцэцэг, 10.9 хувийг цусан суулга, 9.8 хувийг трихомониаз, 9.4 хувийг заг хүйтэн, 9.2 хувийг гар хөл амны өвчин, 3.4 хувийг вируст гепатит өвчнөөр өвчлөгсөд тус тус эзэлж байна.

Хүснэгт 33. Нийслэлд гарсан халдварт өвчин

	хэмжих нэгж	2013 он	2014 он	өсөлт, бууралт	
				тоо/пункт	хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн бүх хүн, үүнээс	бодит тоо	18405	17610	- 795	- 4.3
	10000 хүнд	151.26	141.22	- 10.04	
Вируст гепатит	бодит тоо	1207	603	- 604	- 2.0 дах
	10000 хүнд	9.92	4.84	- 5.08	
Менингит	бодит тоо	17	5	- 12	- 3.4 дах
	10000 хүнд	0.14	0.04	- 0.1	
Цусан суулга	бодит тоо	1573	1921	348	22.1
	10000 хүнд	12.93	15.40	2.47	
Салхин цэцэг	бодит тоо	2552	2305	- 247	- 9.7
	10000 хүнд	20.97	18.48	- 2.49	
Гахай хавдар	бодит тоо	1487	188	- 1299	- 7.9 дах
	10000 хүнд	12.22	1.51	- 10.71	
Сальмонеллөз	бодит тоо	49	72	23	1.5 дах
	10000 хүнд	0.40	0.58	0.18	
Улаан эсэргэнэ	бодит тоо	259	270	11	4.2
	10000 хүнд	2.13	2.17	0.04	
Хоолны хордлого	бодит тоо	121	235	114	1.9 дах
	10000 хүнд	0.99	1.88	0.89	
Ёлом	бодит тоо	109	104	- 5	- 4.6
	10000 хүнд	0.90	0.83	- 0.07	
Бруцеллөз	бодит тоо	14	17	3	21.4
	10000 хүнд	0.12	0.14	0.02	
Нярайн халдвар	бодит тоо	2	4	2	2.0 дах
	10000 хүнд	0.02	0.03	0.01	
Гар хөл амны өвчин	бодит тоо	1262	1614	352	1.3 дах
	10000 хүнд	10.37	12.94	2.57	
Тэмбүү	бодит тоо	3269	3618	349	10.7
	10000 хүнд	26.87	29.01	2.14	
Заг хүйтэн	бодит тоо	1767	1650	- 117	- 6.6
	10000 хүнд	14.52	13.23	- 1.29	
Трихомониаз	бодит тоо	1850	1723	- 127	- 6.9
	10000 хүнд	15.20	13.82	- 1.38	
Шинээр илэрсэн сүрьеэ	бодит тоо	2401	2544	143	6.0
	10000 хүнд	19.73	20.40	0.67	
ДОХ	бодит тоо	23	31	8	34.8
	10000 хүнд	0.19	0.25	0.06	



МЭДЭЭЛЭЛ, ХОЛБОО


Шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээний орлого 2014 онд 726.0 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 106.8 тэрбум төгрөгөөр буюу 17.3 хувиар өсчээ. Нийт орлогын 72.5 хувь буюу 526.1 тэрбум төгрөгийг нийслэл хотын хүн амд үзүүлсэн үйлчилгээнээс бүрдүүлсэн байна.

Хүснэгт 34. Холбооны салбарын үндсэн үзүүлэлт

	Хэмжих нэгж	2013 он	2014 он
Нийт орлого	сая төг	619126.4	725995.8
Үүнээс: хүн амаас	сая төг	462850.1	526130.1
Суурин телефон цэг	тоо	175496	189483
Үүнээс: айл өрхийн	тоо	122965	158027
Утасгүй телефон	тоо	3593	876
Үүрэн телефон хэрэглэгч	мянган хүн	1745.5	1772.2
КаТВ-ийн хэрэглэгч	тоо	234456	298310

2014 онд нийслэлийн хэмжээнд суурин телефон цэгийн тоо 189.5 мянга орчим болж, өмнөх онтой харьцуулахад 8.0 хувиар нэмэгджээ. Нийт суурин телефон цэгийн 158.0 мянга буюу 83.4 хувийг айл өрх ашиглаж байна. Өрхийн суурин телефон цэгийн тоо 2013 оныхоос 28.5 хувиар өссөн нь гурвалсан үйлчилгээний суурин утасны үйлчилгээг хэрэглэгч өрхийн тоо нийслэлд өсөн нэмэгдэж байгаатай холбоотой.

Зураг 26. Суурин телефон цэгийн тоо




Зураг 27. Үүрэн холбооны хэрэглэгчийн тоо



2014 онд Монгол Улсын хэмжээнд давхардсан тоогоор нийт 3.5 сая гаруй хүн үүрэн телефон хэрэглэж байгаагийн 57.9 хувь буюу 1.8 сая орчим хэрэглэгч нь нийслэл хотод байна. Өмнөх онтой харьцуулахад үүрэн телефон хэрэглэгчийн тоо нийслэлд 26.7 мянгаар нэмэгдсэн байна.

Үүрэн холбооны нийт хэрэглэгчдийн 292.1 мянга нь дараа төлбөрт үйлчилгээний, 1480.1 мянга нь урьдчилсан төлбөрт үйлчилгээний хэрэглэгчид байна. Хөдөлгөөнт утасгүй телефон буюу WLL үйлчилгээний хэрэглэгчдийн тоо 0.8 мянга болж 2013 оны дүнгээс эрс буурсан нь F-zone үйлчилгээний хэрэглэгчдийг CDMA болон GSM системд шилжүүлэх техникийн зохицуулалт хийгдсэнтэй холбоотой. Нийслэлд 0.9 мянган хэрэглэгч сансарын холбоог эзэмшдэг байна.

Зураг 28. КаТВ, сувагт холбогдсон хэрэглэгчийн тоо



2014 оны турш кабелийн телевизийн үйлчилгээг 18 аж ахуйн нэгж нийслэлийн 298.3 мянган хэрэглэгчдэд хүргэжээ.

Кабелийн сувагт холбогдсон нийт хэрэглэгчдийн 94.8 хувийг айл өрх эзэлж байна.

Кабелийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт аж ахуйн нэгжийн 16 нь нийслэлийн төвийн 6 дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж, хоногт дундажаар 50-110 гаруй сувгаар үйлчилгээ

хүргэсэн байна. Нийслэлийн Налайх, Багануур дүүргийн хэрэглэгчдийн хувьд 49-63 хүртэл сувгаар кабелийн телевизийн үйлчилгээг хүлээн авч байна.

Гурвалсан үйлчилгээнээс бусад кабелийн телевизийн сувагт холбогдох шинэ тавилтын үнэ нийслэлийн төвийн 6 дүүргийн айл өрхөд 10.0-100.0 мянган төгрөгийн хооронд байхад үйлчилгээний төлбөрийн сарын хураамж өрхөд 4000-11000 төгрөгийн тарифтай байв.



НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ


2014 онд Нийслэлийн Тээврийн газраас Улаанбаатар хотын дотор болон хот орчимд 4.3 мянга гаруй км урттай, 137 чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээг үзүүлжээ.

2014 онд нийтийн тээврийн үйлчилгээнд шинээр 27 чиглэл (үндсэн чиглэл 6, туслах чиглэл 20, шөнийн тээврийн чиглэл 1) нэмэгдсэн байна.

Зураг 29. Зорчигч тээврийн чиглэлийн тоо




Зураг 30. Зорчигч тээврийн чиглэлийн урт



НИТХ-ын 2014 оны 8-р сарын 13-ны өдрийн 132-р тогтоолоор “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ байгуулагдаж, нийслэлийн өмчит гурван байгууллага нэгдсэн байна.

Улаанбаатар хотод 2014 онд нийтийн тээврийн үйлчилгээг 57 аж ахуйн нэгж эрхэлсэн нь өмнөх оноос 3 аж ахуйн нэгжээр цөөрчээ. Их, дунд, бага багтаамжийн автобусны аж ахуйн нэгжийн тоо нийтдээ долоогоор буурч, такси үйлчилгээний аж ахуйн нэгжийн тоо 18 болж өмнөх оноос зургаагаар нэмэгдсэн байна.

Зураг 31. Зорчигч тээврийн үйлчилгээний ААН-ийн тоо



Нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгжүүд 2014 онд 968.7 сая хүн километрийн ажил үйлчилгээг гүйцэтгэн, давхардсан тоогоор нийтдээ 284.9 сая хүн тээвэрлэж, 106.6 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оноос зорчигчийн тоо 8.4 хувиар буюу 22.1 мянган хүнээр, үйлчилгээний орлого 10.6 хувиар буюу 10.2 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.

Хүснэгт 35. Нийтийн тээврийн үйлчилгээ, төлбөрийн хэлбэрээр, 2014 он


Тээврийн хэрэгсэл, төрөл, өмчлөлөөр	Аж ахуйн нэгж (тоо)	Тээврийн хэрэгсэл (тоо)	Орлого (тэрбум төгрөг)	Үүнээс:		Зорчигч (сая хүн)	Үүнээс:	
				зорчих тасал-бараар	нөхөн олговроор		зорчих тасал-бараар	нөхөн олговроор
Зорчигч тээврийн нэгтгэл (ОНӨААТҮГ)*	1	302	36.8	19.6	17.2	101.0	55.8	45.2
Автобус (хувийн)	19	839	64.1	22.7	41.4	170.1	61.4	108.7
Троллейбус (хувийн)	1	14	0.9	0.4	0.5	2.8	1.4	1.4
Бага, дунд багтаамжийн автобус	18	527	4.8	4.6	0.2	11.0	10.6	0.4
Дүн	39	1682	106.6	47.3	59.3	284.9	129.2	155.7

2014 онд бүрдүүлсэн үйлчилгээний нийт орлогын 44.3 хувийг шугамын орлого, 55.7 хувийг “нөхөн олговор”-ын орлого эзэлж байна. Нийтийн тээврээр зорчигчдын 45.4 хувь нь зорчих тасалбар худалдан авч үйлчлүүлсэн байхад 54.6 хувь нь нөхөн олговрын хөнгөлөлтөөр зорчжээ. Өөрөөр хэлбэл нийтийн тээврийн хэрэгслээр 2014 оны туршид давхардсан тоогоор


* Тус нэгтгэлд Автобус 1, Автобус 3, Цахилгаан тээвэр гэсэн 3 байгууллага нэгдэж, зорчигч тээврийн үйлчилгээг явуулж байна.

155.7 сая зорчигч үнэ төлбөргүй үйлчлүүлж, эдгээр хүмүүсийн үйлчилгээний төлбөрт төрөөс 59.4 тэрбум төгрөгийг нөхөн олговор хэлбэрээр тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдэд шилжүүлсэн байна.

Зураг 32. Зорчигчдын тоо, сая хүн, төлбөрийн хэлбэрээр



Зураг 33. Үйлчилгээний орлого, тэрбум төгрөг, төлбөрийн хэлбэрээр



Нийслэлийн Тээврийн газраас аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан “Нийтийн тээврийн үйлчилгээг эрхлэн гүйцэтгүүлэх тухай гэрээ”-гээр насанд хүрэгчид их, дунд багтаамжийн автобусаар 500 төгрөг, цахилгаан тээврээр 300 төгрөг, туслах болон буухиа чиглэлийн бага багтаамжийн автобусаар 500-1300 төгрөг, хот орчмын чиглэлийн бүх төрлийн автобусаар 500-2300 төгрөгөөр (хүүхэд 200-1200 төгрөг) зорчиж байна. Мөн тус гэрээнд таксины үйлчилгээний нэг төлбөрт километрийн тарифыг 1000 төгрөгөөр тогтоож, үйлчилгээнд мөрдүүлэхээр заасан байна.

Хүснэгт 36. Нийтийн тээврийн хөдлөх бүрэлдэхүүний тоо

Дансны хөдлөх бүрэлдэхүүн		2013 он	2014 он
Бүгд		2648	2343
Их багтаамжийн автобус	Төрийн өмч	250	252
	Хувийн өмч	798	839
Бага, дунд багтаамжийн автобус (хувийн)	Туслах чиглэл	408	224
	Буухиа чиглэл	477	303
Троллейбус	Төрийн	51	50
	Хувийн	15	14
Такси		649	661

Нийслэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ нь 2014 онд зориулалтын 2343 хөдлөх бүрэлдэхүүнтэй ажиллажээ.

Эдгээрийн 22.5 хувь нь бага, дунд багтаамжийн автобус, 46.6 хувь нь их багтаамжийн автобус, 28.2 хувь нь такси байна.

2014 онд нийтийн тээврийн парк шинэчлэлтээр 8 троллейбус, их багтаамжийн 121 автобус, 120 такси үйлчилгээнд шинээр нэмэгдэж, стандартын шаардлага хангахгүй болж 12-оос дээш

жилээр ашиглагдаж хуучирсан 787 тээврийн хэрэгсэл (их багтаамжийн хувийн 74, бага багтаамжийн 516 автобус, 192 такси) үйлчилгээнээс хасагдсан байна.

2014 онд өдөрт дунджаар их, дунд багтаамжийн 850 автобус, 43 троллейбус, бага багтаамжийн 419 автобус, 529 такси, хот орчмын чиглэлд 65 тээврийн хэрэгсэл нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллажээ. Шугаманд өдөрт ажилласан нийт тээврийн хэрэгслийн 80.7 хувийг хувийн хэвшлийн тээврийн хэрэгсэл эзэлж байв.

Зураг 34. Хүлээлтийн хугацаа, минут



Зураг 35. Өдөрт ажилласан тээврийн хэрэгсэл, тоо



2014 онд нийслэлийн зорчигч тээврийн үйлчилгээний чиглэлүүдийн давхцалыг арилгах арга хэмжээ авсаны зэрэгцээ үндсэн чиглэлийн урт нэмэгдэж, туслах чиглэлд ажиллах тээврийн хэрэгслийн тоо эрс цөөрсөн. Үүний улмаас үйлчилгээнд өдөрт ажиллах тээврийн хэрэгслийн тоо өмнөх оноос 12.3 хувиар буурсан байна. Энэ нь зогсоолд ирэх автобус хоорондын зай буюу хүлээлтийн хугацаа өсөхөд нөлөөлсөн. Нийтийн тээврийн хүлээлтийн дундаж хугацааг өмнөх онтой харьцуулахад цахилгаан тээврийнх 2.4 минутаар, их багтаамжийн автобусны хүлээлтийн хугацаа 1.0 минутаар, бага, дунд багтаамжийн автобусных 2.6 минутаар тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 37. Автобусны буудлын тоо, төвийн дүүргүүдээр


Дүүрэг	2012 он		2013 он		2014 он			Зогсоолын талбай нь стандартын шаардлага хангасан	Зогсоолын тэмдэгтэй
	Бүгд	Эцсийн зогсоол	Бүгд	Эцсийн зогсоол	Бүгд	Үүнээс:			
						Эцсийн	Дундын		
Хан-Уул	79	10	59	9	59	9	50	19	17
Баянзүрх	132	24	190	19	190	19	171	35	61
Баянгол	56	6	76	3	76	3	73	48	31
Сүхбаатар	50	5	119	5	119	5	114	15	32
Чингэлтэй	114	14	72	7	72	7	65	18	26
Сонгинохайрхан	138	25	195	25	195	25	170	62	105
Нийт	569	84	711	68	711	68	643	197	272

Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны дундын болон эцсийн зогсоолын байршлыг тогтоох, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, тогтоосон байршлыг баталгаажуулах ажил үргэлжлэн хийгдэж байна. Нийслэлийн төвийн 6 дүүргийн хэмжээнд 2014 онд нийтдээ 711


автобусны буудал, зогсоол ажиллажээ. Нийт зогсоолын 66.2 хувь нь автобус зогсох зориулалтын талбайтай, 14.3 хувь нь саравчтай, 54.6 хувь нь орчны гэрэлтүүлэгтэй ажээ. Нийт буудал, зогсоолын 9.6 хувийг “эцсийн”, 90.4 хувийг “дундын зогсоол” эзэлж байгаа бөгөөд 27.7 хувь нь стандартын шаардлага хангасан, 38.3 хувь нь автобусны зогсоолын тэмдэгтэй болоод байна.

Нийслэлд ажиллаж буй автобусны буудал, зогсоолын хамгийн олонх нь буюу 26.7-27.4 хувь нь нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт байршдаг байна. Түүнчлэн автобусны арван буудал тутмын нэг нь Чингэлтэй, Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт тус тус байрлаж байхад Хан-Уул дүүрэгт хамгийн цөөн буюу 59 буудал, зогсоол байрладаг байна.

Зураг 36. Зогсоол хоорондын зай



Зураг 37. Уулзвар гарцтай ойр байрласан эсэх




2014 онд нийслэлийн зорчигч тээврийн үйлчилгээний талаар иргэдээс дараах төрлийн нийт 1835 санал, гомдол Нийслэлийн Тээврийн газарт ирүүлсэний 94.4 хувийг нь шийдвэрлэж, барагдуулсан байна. Үүнд:

Зураг 38. НТ-ийн үйлчилгээний талаарх санал, гомдол, жил бүрийн эцэст



Зураг 39. Үйлчилгээний талаар ирүүлсэн санал, гомдлын шийдвэрлэлт



Автомашинны тоо

2014 оны техникийн хяналтын үзлэгийн дүнгээр Улаанбаатар хотод нийтдээ 297.0 мянган тээврийн хэрэгсэл хамрагдсан байна. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт тээврийн хэрэгслийн 74.0 хувийг суудлын автомашин эзэлж байгаа бол 18.5 хувь нь ачааны, 3.8 хувь нь автобус, 3.7 хувь нь тусгай зориулалтын автомашин байна.

Хүснэгт 38. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан автомашинны тоо

	2012 он	2013 он	2014 он	Автомашинны үндсэн төрлөөр				Амины автомашин	
				Суудлын	Ачааны	Автобус	Тусгай	2013 он	2014 он
Нийслэлийн дүн	228952	257498	297008	219679	55034	11421	10874	203573	238183
Багануур	1670	1622	2314	1585	562	133	34	1365	2026
Багахангай	275	290	435	285	118	28	4	249	382
Баянгол	48913	57291	63918	47968	11188	2114	2648	46413	52305
Баянзүрх	56394	64655	77148	57457	14775	2773	2143	51340	61793
Налайх	2082	1946	2419	1569	729	96	25	1855	2334
Сонгинохайрхан	40402	45198	51477	37493	10511	2227	1246	40853	47065
Сүхбаатар	33340	35815	39780	29106	6837	1745	2092	22576	25686
Хан-Уул	20698	22208	27036	19756	4495	1115	1670	16526	20910
Чингэлтэй	25178	28473	32481	24460	5819	1190	1012	22396	25682

Хүснэгт 39. Автомашины тоо, өмчийн хэлбэрээр, 2014 он

		Бүгд	Үүнээс: Автомашины үндсэн төрлөөр			
			Суудлын	Ачааны	Автобус	Тусгай зориулалт
Нийслэлийн дүн		297008	219679	55034	11421	10874
Аж ахуйн нэгжийн автомашин	Төрийн болон орон нутгийн өмчийн	3457	1957	486	659	355
	Дипломат, олон улсын байгууллагын	475	377	44	46	8
	Төрийн бус байгууллагын	3095	1335	778	178	804
	Компани, хоршоо, нөхөрлөлийн	51798	28221	12540	3856	7181
Амины автомашин		238183	187789	41186	6682	2526

2014 оны техникийн хяналтын үзлэгийн нийслэлийн дүнгээр нийт тээврийн хэрэгслийн 19.8 хувь нь аж ахуй нэгж, байгууллагын эзэмшилд бүртгэлтэй байгаагийн 1.2 хувийг төрийн болон орон нутгийн өмчийн, 0.2 хувийг дипломат болон олон улсын байгууллагын, 1.0 хувийг төрийн бус байгууллагын, 17.4 хувийг компани, хоршоо, нөхөрлөлийн автомашин тус тус эзэлж байна. Хувь хүмүүс, иргэдийн эзэмшилд бүртгэлтэй амины автомашины тоо 238.2 мянгад хүрсэн бөгөөд нийт автомашины 80.2 хувийг эзэлж байна.

Хүснэгт 40. Автомашины тоо, ашиглалтын хугацаа, дүүргээр

Дүүрэг	2013 он				2014 он			
	Бүгд	0 - 3 жил	4 - 9 жил	10-аас дээш	Бүгд	0 - 3 жил	4 - 9 жил	10-аас дээш
Нийслэлийн дүн	257498	19949	63770	173779	297008	16686	69883	210439
Багануур	1622	31	230	1361	2314	46	325	1943
Багахангай	290	11	40	239	435	11	71	353
Баянгол	57291	4757	15849	36685	63918	3856	16730	43332
Баянзүрх	64655	4037	16410	44208	77148	3391	17962	55795
Налайх	1946	33	336	1577	2419	32	329	2058
Сонгинохайрхан	45198	1393	10039	33766	51477	1098	10286	40093
Сүхбаатар	35815	4435	8917	22463	39780	3780	10252	25748
Хан-Уул	22208	3335	5000	13873	27036	2867	6552	17617
Чингэлтэй	28473	1917	6949	19607	32481	1605	7376	23500

Улаанбаатар хотод техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт тээврийн хэрэгслийн ихэнх буюу 70.8 хувийг арав ба түүнээс дээш жилээр ашиглаж, хуучирсан тээврийн хэрэгслүүд эзэлж байна. Энэ ангилалд харъяалагдаж буй 210.4 мянган тээврийн хэрэгслийн 66.2 хувь нь нийслэлийн Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан дүүрэгт ногдож байгаагийн дотор 10 ба түүнээс дээш жилээр ашигласан нийт автомашин 26.5 хувь нь Баянзүрх дүүрэгт ногдож байна.


Үйлдвэрлэж гарсан хугацаанаас хойш 0-3 жил ашиглаж буй шинэ автомашины тоо нийт тээврийн хэрэгслийн 5.6 хувийг эзэлж байгаа нь өмнөх оныхоос 2.1 пунктээр буурсан байна. Уг ангилалд бүртгэгдсэн тээврийн хэрэгслийн дийлэнх буюу 83.3 хувь нь нийслэлийн Баянгол (23.1%), Сүхбаатар (22.7%), Баянзүрх (20.3%), Хан-Уул (17.2%) дүүрэгт тус тус бүртгэлтэй байна.

Хүснэгт 41. Автомашины тоо, хөдөлгүүрийн төрлөөр

	Бүгд	Үүнээс: Автомашины үндсэн төрлөөр									
		Суудлын		Ачааны		Автобус		Тусгай зориулалт			
		2013 он	2014 он	2013 он	2014 он	2013 он	2014 он	2013 он	2014 он		
Нийслэлийн дүн	257498	297008	184371	219679	51409	55034	11430	11421	10288	10874	
Хөдөлгүүрийн төрөл	Бензин	143296	160868	137433	154611	3892	4186	1612	1598	359	473
	Дизель	82580	87931	15721	17469	47202	50377	9740	9698	9917	10387
	Цахилгаан	22093	37172	22050	37081	25	29	18	61	-	1
	Газ	9529	11037	9167	10518	290	442	60	64	12	13

Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийслэлийн 297.0 мянган автомашиныг хөдөлгүүрийнх нь шатахууны төрлөөр ангилж үзэхэд 54.2 хувь нь “бензин хөдөлгүүр”-тэй автомашин эзэлж, энэ төрлийн автомашины тоо 2013 оныхоос 12.3 хувиар нэмэгджээ. Сүүлийн жилүүдэд газ болон цахилгаан хөдөлгүүртэй автомашины тоо аажмаар нэмэгдэж буй төлөв байдал ажиглагдах болсон. Түүнчлэн 2014 онд дизель хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн эзлэх хувийн жин 29.6 болж, өмнөх оны дүнгээс 2.5 пунктээр доошилсон байна.

Зураг 40. Автомашины тоо, хүрдний байрлалаар, 2014 он



Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт автомашины 57.5 хувийнх нь жолооны хүрд баруун талдаа буюу “буруу талдаа” байрлалтай байна. Эдгээрийн дийлэнх буюу 94.1 хувийг “суудлын автомашин” дангаараа эзэлж байгаа юм.

Суудлын нийт автомашины 73.2 хувь нь баруун талдаа, 26.8 хувь нь зүүн талдаа хүрдний байрлалтай ажээ.

Зүүн талдаа буюу бидний хэлж заншнаар “зөв талдаа” хүрдний

байрлалтай автомашинуудын хувьд суудлын автомашинаас бусад гурван төрлийн тээврийн хэрэгслийн тоо хэмжээ баруун талдаа хүрдний байрлалтай тээврийн хэрэгслээс илүү олон байгаа юм. Өөрөөр хэлбэл, замын хөдөлгөөний дүрэмдээ баруун гарын дүрэм баримталдаг (зөв талдаа буюу жолооны хүрд нь зүүн талдаа байрлалтай тээврийн хэрэгсэл ашиглах) манай улс, нийслэлийн хувьд энэ нь эерэг үзүүлэлт юм. Тухайлбал, ачааны нийт машины 84.3 хувь, автобусны 93.0 хувь, тусгай зориулалтын автомашины 94.2 хувь нь зөв талдаа байрласан жолооны хүрдтэй байна.



ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Нийслэлийн хүн амд 2014 оны байдлаар 32.6 сая м³, аж ахуйн нэгж, байгууллагад 12.8 сая м³ цэвэр усыг борлуулжээ. Борлуулсан усны нийт хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 0.7 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 42. Ус суваг ашиглалтын үйлчилгээ


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2013 он XII сар	2014 он XII сар	2014/2013 %
Шахсан ус	мян.м ³	55195.9	53617.6	97.1
Борлуулсан ус	мян.м ³	45025.1	45346.5	100.7
Хүн амд	мян.м ³	32888.3	32579.0	99.1
ААНБ-д	мян.м ³	12136.8	12767.5	105.2
Татан зайлуулсан бохир	мян.м ³	44070.3	44206.2	100.3
Хүн амаас	мян.м ³	30660.3	30220.6	98.6
ААНБ-аас	мян.м ³	13410.0	13985.6	104.3
Ус борлуулалтын орлого	сая төг	16169.4	20819.1	128.8
Хүн амаас	сая төг	9293.8	11498.9	123.7
ААНБ-аас	сая төг	6875.6	9320.2	135.6
Сувагжуулалтын орлого	сая төг	8992.3	11968.1	133.1
Хүн амаас	сая төг	4513.9	5321.8	117.9
ААНБ-аас	сая төг	4478.4	6646.3	148.4

Нийт борлуулсан усны 70.7 хувийг хүн амд борлуулсан ус, 29.3 хувийг аж ахуйн нэгж, байгууллагад борлуулсан ус эзэлж байна.

Хүн амд түгээсэн цэвэр усны 95.9 хувь буюу 31.3 сая м³-ыг нь төвлөрсөн шугамаар, 1.3 сая м³ усыг “ус түгээх байр”-аар, 11.7 мянган м³ усыг тээврээр түгээсэн байна.

Цэвэрлэх байгууламжаар 59.2 сая м³ бохирыг цэвэрлэж, аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн 44.2 сая м³ бохир шингэнийг татан зайлуулсан байна.

Зураг 41. Борлуулсан ус, сараар, мян.м³



АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

Нийслэлийн агаарын дундаж температур 2014 оны 12 сард дунджаар -16.6⁰С байв. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс -0.7⁰С-аар, олон жилийн дундажтай харьцуулахад -0.7⁰С-аар тус тус хүйтэн байлаа.

Энэ сард үнэмлэхүй их температур -6.3⁰С, үнэмлэхүй бага температур -26.7⁰С, хур тунадасны нийлбэр 3.2 мм, салхины үнэмлэхүй их хурд 12 м/секунд хүрч, шороон болон цасан шуургатай 1 тохиолдлыг бүртгэжээ.


Агаар дахь бохирдуулагч бодисын агууламжийг нийслэл хотын нутаг дэвсгэрт 8 харуул цэгт хэмжихэд азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 2014 оны 12 дугаар сард Улаанбаатар хотын 13-р хороолол орчимд 31 удаа, 32-ын тойрог орчимд 30 удаа, Баруун дөрвөн замын орчимд 29 удаа, Ургах наран хороолол орчимд 21 удаа, 1-р хороолол болон Офицеруудын ордон орчимд тус бүр 12 удаа, хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламж 13-р хороолол болон 32-ын тойрог орчимд тус бүр 31 удаа, Ургах наран хороолол орчимд 28 удаа, Баруун дөрвөн замын орчимд 27 удаа, Мишээл экспо төв болон Хархорин захын орчимд тус бүр 23 удаа, Офицеруудын ордон орчимд 22 удаа, 1-р хороолол орчимд 20 удаа тус тус давжээ.

Хүснэгт 43. Агаарын бохирдолт, мг/м³

Бодисын нэр		Стандарт хэмжээ	Хийсэн ажиглалтын тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдол /тоо/	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий	SO ₂	0.020	220	0.110	205	0.045
Азотын давхар исэл	NO ₂	0.040	170	0.102	135	0.057
Тоосжилт	PM ₁₀	0.100	137	0.821	122	0.237
	PM _{2.5}	0.050	60	0.336	55	0.148
Нүүрстөрөгчийн дутуу исэл	CO	10.0	431	6.663	-	1.680
Озон	O ₃	0.100	266	0.050	-	0.011

Мэдээллийн эх үүсвэр: Ус, цаг уур орчны хүрээлэн

Зураг 42. Хүхэрлэг хийн агууламж, мг/м³




Зураг 43. Азотын давхар ислийн агууламж, мг/м³




10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж 32-ын тойрог орчимд 31 удаа, 13-р хороолол орчимд 28 удаа, Хархорин захын орчимд 24 удаа, Ургах наран хороолол орчимд 23 удаа, Баруун дөрвөн зам орчимд 16 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж 13-р хороолол орчимд 28 удаа, Баруун дөрвөн замын орчимд 27 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давсан байна.

Зураг 44. Тоосны /PM₁₀/ агууламж, мг/м³



Зураг 45. Нүүрстөрөгчийн дутуу исэл, мг/м³



Хүснэгт 44. Агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м³, 12-р сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл Экспо төв	Баруун дөрвөн зам	1-р хороо лол	13-р хороо лол	32-ын тойрог	Офицер- уудын Ордон	Хар- хорин зах	Ургах наран хороо- лол
Хүхэрлэг хий SO ₂	Дундаж	0.029	0.049	0.051	0.052	0.058	0.055	0.024	0.040
	Хамгийн их	0.044	0.076	0.097	0.085	0.094	0.110	0.041	0.072
	XXX*-с давсан хувь	82.1	93.1	100.0	100.0	100.0	91.7	82.1	96.6
	Хэмжилтийн тоо	28	29	20	31	31	24	28	29
Азотын давхар Исэл NO ₂	Дундаж	-	0.078	0.043	0.071	0.056	0.043	-	0.052
	Хамгийн их	-	0.099	0.078	0.102	0.072	0.102	-	0.077
	XXX*-с давсан хувь	-	100.0	50.0	100.0	96.8	46.2	-	72.4
	Хэмжилтийн тоо	-	29	24	31	31	26	-	29
Нүүрс- төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж	-	2.621	-	1.574	1.873	-	1.636	0.695
	Хамгийн их	-	5.350	-	4.638	6.663	-	4.625	2.188
	XXX*-с давсан хувь	-	0	-	0	0	-	0	0
	Хэмжилтийн тоо	-	76	-	93	92	-	87	83
Тоос PM10	Дундаж	-	0.294	-	0.217	0.379	-	0.155	0.138
	Хамгийн их	-	0.720	-	0.464	0.821	-	0.350	0.268
	XXX*-с давсан хувь	-	94.1	-	90.3	100.0	-	88.9	74.2
	Хэмжилтийн тоо	-	17	-	31	31	-	27	31
Тоос PM2.5	Дундаж	-	0.186	-	0.109	-	-	-	-
	Хамгийн их	-	0.336	-	0.174	-	-	-	-
	XXX*-с давсан хувь	-	93.1	-	90.3	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	29	-	31	-	-	-	-
Озон O ₃ **	Дундаж	0.011	-	-	0.007	0.005	-	-	0.021
	Хамгийн их	0.034	-	-	0.028	0.015	-	-	0.050
	XXX*-с давсан хувь	0	-	-	0	0	-	-	0
	Хэмжилтийн тоо	65	-	-	21	92	-	-	88

*- Хүлцэх хэм хэмжээ, **- CO, O₃ -ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон.

Хүснэгт 45. Нийслэлийн гадаргын усны найрлага, мг/м³, 12-р сард

	Стандарт хэмжээ	"Туул-Налайх" харуул цэг		"Туул-Сонгино доод" харуул цэг	
		Хэмжээ	Бодисын хэтрэлт	Хэмжээ	Бодисын хэтрэлт
Хүчилтөрөгч (O ₂)	≥6	9.56	хэвийн	0	онцгой их бохирдолтой
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч (БХХ ₅)	≤ 3	1.0		230.0	76.7 дахин
Нитридийн нэгдэл (NO ₂)	≤ 0.02	0.002		0.075	3.8 дахин
Амоны азот (NH ₄)	≤0.5	0.05		15.87	31.7 дахин
Эрдэс фосфор (P)	≤0.1	0.002		0.748	7.5 дахин

Мэдээллийн эх үүсвэр : Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори

Туул голын усны найрлага Туул-Налайх харуул цэгийн орчимд бохирдуулагч бодисын хэмжээ хэвийн, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд хүчилтөрөгчийн хэмжээ горим алдагдаж онцгой их бохирдолтой, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 76.7 дахин, амоны азот 31.7 дахин, эрдэс фосфор 7.5 дахин, нитридийн нэгдэл 3.8 дахин хүлцэх хэм хэмжээнээс хэтэрч Туул голын ус маш бохирдолтой хэвээр байна. Туул-Зайсан харуул цэгийн орчимд голын ус хөлдсөн тул хэмжилт хийгдээгүй.

Байгаль орчны зөрчил Нийслэлд 2014 онд байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийг зөрчсөн 255 зөрчлийг илрүүлжээ. Зөрчлийн тоо өмнөх оны мөн үеэс 5.9 хувиар буурч, нийт зөрчлийн 27.5 хувийг газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхайн зөрчил, 17.6 хувийг газрын зөрчил, 14.1 хувийг агаар, химийн хорт бодисын зөрчил, 9.4 хувийг ойн зөрчил, 7.8 хувийг геодези зураг зүй, кадастрын зөрчил, 6.3 хувийг ургамал, хөрсний бохирдлын зөрчил, 2.0 хувийг ангийн зөрчил, 1.2 хувийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, 0.8 хувийг усны зөрчил, 13.3 хувийг бусад зөрчлүүд тус тус эзэлж байна.

Илрүүлсэн нийт зөрчилд 94.8 сая төгрөгийн торгууль ногдуулж, ойн зөрчил гаргасан иргэдээс 3.1 сая төгрөгийн эд зүйлс хураан авчээ.

Хүснэгт 46. Байгаль орчны зөрчил, төрлөөр

Илрүүлсэн зөрчил, төрлөөр	2013 он			2014 он		
	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль /сая.төг/	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль /мян.төг/
Ой	67	108	20.0	38	24	8.7
Ан, амьтан	11	6	0.8	7	5	-
Газрын	66	39	33.4	91	45	31.5
Ус	16	8	10.4	4	2	3.8
Ургамал, хөрсний бохирдол	70	63	2.4	15	16	2.6
Агаар, химийн хорт бодис	17	15	0.5	57	36	2.5
Газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхай	19	6	4.1	156	70	24.1
Геодези зураг зүй, кадастр	22	15	1.4	31	20	2.5
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	-	-	-	2	3	14.4
Бусад	17	11	5.2	63	34	4.7
Бүгд	305	271	78.2	464	255	94.8

ХОТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ



Нийслэл хотын нутаг дэвсгэрт 2014 онд нийт 433 гамшиг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23.2 хувиар буурчээ.

Нийт гамшигт гахайн мялзан өвчний 2 тохиолдол, гахайн үржил-амьсгалын замын хам шинж өвчний 2 тохиолдол бүртгэгдэж, 1323 гахайг устгасан байна. Мөн үхрийн хорт салст хатуурал өвчний 1 тохиолдол, ус, цаг агаарын гаралтай аюулт үзэгдлийн 6 тохиолдол бүртгэгджээ. Харин хүний үйл ажиллагаатай холбоотой тэсэрч дэлбэрэх бодисын осол 2, сум галт хэрэгслийн

осол 9, химийн бодисын осол 25, бичил уурхай, нурангины осол 5, усны осол 9, барилгын осол 3, үйлдвэрийн осол 2, бусад осол 367 тохиолджээ.

Гамшгийн улмаас 49 хүн амь насаа алдсан байна. Гамшгаас 479 хүнийг аварч, гамшгийн уршгийг арилгах ажилд нийт 47.2 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 47. Хүний үйл ажиллагаатай холбоотой осол, төрлөөр

Ослын төрөл	2013 он	2014 он	$\frac{2014}{2013}$
Бүгд	542	422	77.9
Тэсэрч дэлбэрэх бодисын	4	2	50.0
Сум галт хэрэгслийн	7	9	128.6
Химийн бодисын	49	25	51.0
Бичил уурхай, нурангины	8	5	62.5
Усны осол	8	9	112.5
Барилгын осол	4	3	75.0
Үйлдвэрийн осол	3	2	66.7
Бусад	459	367	80.0

Нийслэл хотод 2014 онд ой хээрийн түймэр 4, ахуйн 3040 гал түймэр гарчээ. Ахуйн гал түймрийн 37 нь Багануур, 6 нь Багахангай, 452 нь Баянгол, 728 нь Баянзүрх, 124 нь Налайх, 466 нь Сүхбаатар, 289 нь Хан-Уул, 347 нь Чингэлтэй, 591 нь Сонгинохайрхан дүүрэгт тус тус гарсан байна. Гал түймрийг гарсан шалтгаанаар нь ангилвал цахилгаанаас 536, санамсаргүй байдлаас 1974, санаатай үйлдлээр 10, шалтгаан тогтоогдоогүй 282, бусад шалтгаанаар 238 гал түймэр гарсан байна.

Гал түймрийн улмаас 40 хүн (үүнээс, хүүхэд 10) амь насаа алдаж, 25 хүн (үүнээс, хүүхэд 3) түлэгдэж гэмтжээ. Гал түймрийн аюулаас 504 хүн, 631 байшин барилга, 18.4 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг аварчээ.

Гал түймэрт иргэний хувийн өмчийн 1830, төрийн өмчийн 989, хувийн аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн 221 объект өртөж, нийт 8200.3 сая төгрөгийн хохирол учирсан байна. Гал түймэрт 1691 гэр, орон сууц, 626 барилга байгууламж, тоног төхөөрөмж, 170 машин техник, 11 малын хашаа, саравч, бусад 542 объект өртсөн байна.

Нийслэлийн Онцгой байдлын газраас 2014 онд 166 барилгын зураг төсөл, ашиглалтанд хүлээн авч буй 561 барилгад хяналт тавьж ажиллажээ. Мөн 22137 айл өрх, 11781 объектод үзлэг шалгалт хийж, 56471 галын зөрчил илрүүлж, 143 байгууллагын үйл ажиллагааг нь зогсоож, байгууллага, албан тушаалтан, иргэнд 2832 заавал биелүүлэх албан шаардлага, 2967 мэдэгдэл хүргүүлж, 60.5 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.




ГЭМТ ХЭРЭГ

2014 онд 17144 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 11.2 хувь буюу 1725 хэргээр өсчээ. Гэмт хэргийн илрүүлэлт 55.3 хувьтай байгаа нь өмнөх оноос 1.2 пунктээр доогуур байна. Гэмт хэргийн улмаас 6556 хүн гэмтэж осолдож, 444 хүн нас барж, төр ард иргэдэд 117.1 тэрбум төгрөгийн хохирол учруулсны 21.1 хувь буюу 24.7 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн

төлүүлжээ.

Зураг 46. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар

Бүртгэгдсэн гэмт хэргийн 30.3 хувийг хулгайн, 27.9 хувийг хүний эрх, эрх чөлөөний эсрэг, 9.1 хувийг залилан, 7.8 хувийг танхайн, 6.2 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг тус тус эзэлж байна.



Хүснэгт 48. Нийт бүртгэсэн гэмт хэрэг, төрлөөр

	Гэмт хэргийн тоо		Өсөлт, бууралт	
	2013 он	2014 он	Тоо	Хувь
Хүний амь	104	114	10	9.6
Хүчин	182	152	- 30	- 16.5
Дээрэм	530	591	61	11.5
Хулгай	4638	5194	556	12.0
Булаалт	187	205	18	9.6
Залилан	1014	1557	543	1.5 дах
Хүний эрх, эрх чөлөөний эсрэг	4353	4781	428	9.8
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	1211	1060	- 151	- 12.5
Бусдыг амиа хорлоход хүргэх	178	174	- 4	- 2.2
Ашиглах	193	174	- 19	- 9.8
Танхайрах	1448	1336	- 112	- 7.7
Бусад	1381	1806	425	30.8
БҮГД	15419	17144	1725	11.2

2014 онд 64943 хүн эрүүлжигдсэн нь өмнөх оноос 1.6 хувь буюу 1040 хүнээр өссөн байна.

Хүснэгт 49. Нийт бүртгэсэн гэмт хэрэг, дүүргээр

дүүрэг	Нийт бүртгэсэн гэмт хэрэг		Гэмт хэргийн өсөлт, бууралт	
	2013 он	2014 он	Тоо	Хувь
Багануур	278	236	- 42	- 15.1
Багахангай	31	23	- 8	- 25.8
Баянгол	2521	2775	254	10.1
Баянзүрх	3742	4263	521	13.9
Налайх	302	339	37	12.3
Сонгинохайрхан	2778	3039	261	9.4
Сүхбаатар	2416	2593	177	7.3
Чингэлтэй	2115	2392	277	13.1
Хан-Уул	1236	1484	248	20.1
ДҮН	15419	17144	1725	11.2

Хүснэгт 50. Гэмт хэрэг бүртгэгдэх үед сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн тоо, дүүргээр, 2014 он

дүүрэг	Сэжигтэн тодорхойгүй хэргийн тоо	Үүнээс сэжигтнийг илрүүлж ял сонгосон	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
Багануур	35	25	71.4
Багахангай	6	4	66.7
Баянгол	1109	705	63.6
Баянзүрх	2676	1290	48.2
Налайх	89	68	76.4
Сонгинохайрхан	1767	1034	58.5
Сүхбаатар	1258	694	55.2
Чингэлтэй	1402	768	54.8
Хан-Уул	667	395	59.2
ДҮН	9009	4983	55.3

Хүснэгт 51. Бүртгэсэн хулгайн гэмт хэрэг, дүүргээр


дүүрэг	Нийт хулгайн гэмт хэргийн тоо		Үүнээс: хувийн өмчийн хулгайн гэмт хэргийн тоо	
	2013 он	2014 он	2013 он	2014 он
Багануур	59	33	40	28
Багахангай	5	5	4	3
Баянгол	637	695	514	557
Баянзүрх	1287	1391	1157	1182
Налайх	52	68	41	58
Сонгинохайрхан	978	1044	909	936
Сүхбаатар	694	834	548	608
Чингэлтэй	571	722	502	649
Хан-Уул	355	402	321	355
ДҮН	4638	5194	4036	4376

Хүснэгт 52. Бүртгэсэн гэмт хэргийн ангилал

	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он
Онц хүнд хэрэг	202	199	268	285	262	360
Хүнд хэрэг	1305	1092	1095	1206	1193	1221
Хүндэвтэр хэрэг	5601	5101	4904	5809	6937	7429
Хөнгөн хэрэг	4231	4471	4506	5610	7027	8134

2014 онд хүнд хэрэг 1221, хүндэвтэр хэрэг 7429, хөнгөн хэрэг 8134, онц хүнд хэрэг 360 бүртгэгдсэн нь өмнөх оноос 2.3-37.4 хувиар өсчээ.

Зураг 47. Гэмт хэргийн тоо, ангиллаар



Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 13315 болж, 2013 оноос 7.7 хувь буюу 954 хүнээр өссөн байна. Сэжигтэн, яллагдагчийн 4.7 хувь буюу 620 нь хүүхэд, 18.0 хувь буюу 2396 нь эмэгтэйчүүд байна.

Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 14.0 хувь буюу 1865 нь гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн, 21.0 хувь буюу 2798 нь согтуугаар үйлдсэн, 4.4 хувь буюу 592 нь урьд ямар нэг ял шийтгэл хүлээж байсан хүмүүс үйлджээ.

Хүснэгт 53. Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо, дүүргээр

	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он
Багануур	344	279	267	308	302	262
Багахангай	23	16	12	23	33	22
Баянгол	1781	1669	1709	1937	2077	2245
Баянзүрх	1756	1975	1741	1830	2673	2906
Налайх	284	318	274	292	304	343
Сонгинохайрхан	1895	1481	1670	1819	2253	2440
Сүхбаатар	1406	1554	1501	1697	1848	1994
Хан-Уул	994	1003	1035	1033	1115	1272
Чингэлтэй	1483	1207	1274	1590	1756	1831
Нийслэлийн дүн	9966	9502	9483	10529	12361	13315

Хүснэгт 54. Гэмт хэрэг үйлдэгсэд, боловсролын түвшнээр, дүүргээр, 2014 он

	Бүх хүн	Боловсролын түвшингээр					
		дээд	Мэргэжлийн анхан шатны	Бүрэн дунд	Суурь	Бага	Боловсролгүй
Багануур	262	46	24	113	54	19	6
Багахангай	22	3	1	7	7	3	1
Баянгол	2245	580	130	1177	236	93	29
Баянзүрх	2906	601	135	1575	423	124	48
Налайх	343	62	9	166	73	23	10
Сонгинохайрхан	2440	282	58	1183	639	163	115
Сүхбаатар	1994	577	64	900	306	99	48
Хан-Уул	1272	391	29	595	190	50	17
Чингэлтэй	1831	422	48	893	323	97	48
Бүгд	13315	2964	498	6609	2251	671	322

Гэмт хэрэгт бүрэн дунд, дээд болон суурь боловсролтой хүмүүс хамгийн ихээр холбогдсон байна. 2014 онд гэмт хэрэг үйлдэгсдийн 49.6 хувь буюу 6609 нь бүрэн дунд боловсролтой, 22.3 хувь буюу 2964 нь дээд боловсролтой, 16.9 хувь буюу 2251 нь суурь боловсролтой, 5.0 хувь буюу 671 нь бага боловсролтой, 3.8 хувь буюу 498 нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 2.4 хувь буюу 322 нь ямар нэгэн боловсролгүй хүмүүс байжээ.

Хүснэгт 55. Гэмт хэрэг үйлдэгсэд, нийгмийн байдлаар, дүүргээр, 2014 он

	Бүх хүн	Үүнээс: нийгмийн байдлаар					
		ХХЭрхлэгч, ажиллагсад, малчин	Төрийн албан хаагч	Оюутан сурагч	ХЦАХаагч, сургууль завсардсан хүүхэд, тэнэмэл иргэн	Хоригдол	Ажилгүй
Багануур	262	72	17	12	1	5	155
Багахангай	22	5	6				11
Баянгол	2245	833	50	198	30	8	1126
Баянзүрх	2906	1140	99	197	34	19	1417
Налайх	343	88	24	27	3		201
Сонгинохайрхан	2440	775	54	103	27	8	1473
Сүхбаатар	1994	876	71	175	25	6	841
Хан-Уул	1272	539	64	103	10	6	550
Чингэлтэй	1831	687	50	122	35		937
Бүгд	13315	5015	435	937	165	52	6711



НИЙСЛЭЛ ХОТЫН ХҮН АМ

2015 оны 1-р сарын 1-ний байдлаар нийслэл хотод 1314.5 мянган хүн байнга оршин сууж байна. Нийт хүн амын 52.2 хувь буюу 686.6 мянга нь эмэгтэйчүүд байна.

Зураг 48. Нийслэлийн хүн амын өсөлт



Нийслэлийн суурин хүн амын тоо 2013 оноос 3.7 хувь буюу 47.5 мянган хүнээр, өрхийн тоо 5.8 хувь буюу 19.4 мянган өрхөөр тус тус өсчээ.

Улаанбаатар хотод амьдарч буй 100-аас дээш настай 44 хүний 9 нь эрэгтэй, 35 нь эмэгтэй хүн байна. Сонгинохайрхан дүүрэгт нийслэлийн хамгийн өндөр настан амьдарч байна.

Хүснэгт 56. Нийслэлийн хүн ам, насны бүлгээр, дүүргээр

	Нийслэлийн нийт хүн ам	үүнээс: дүүргээр								
		Баянзүрх	Сонгино хайрхан	Баянгол	Чингэлтэй	Хан-Уул	Сүхбаатар	Налайх	Багануур	Багахангай
0-4	154393	34832	35804	24672	18527	16971	15755	4316	3016	500
5-9	112618	25650	26757	17584	14002	11666	10898	3189	2498	374
10-14	85648	19414	20995	12359	10608	8311	8900	2712	2052	297
15-19	91648	23222	20533	13468	10856	8706	9659	2627	2273	304
20-24	116953	28461	25533	17908	14394	12214	12126	3133	2806	378
25-29	150537	35996	32618	23402	18542	16359	16912	3567	2711	430
30-34	124864	30449	27662	20500	15107	13471	12116	2922	2344	293
35-39	108447	26323	23880	18303	12826	11444	10652	2678	2069	272
40-44	94255	22693	20516	16074	11003	9942	9460	2220	2104	243
45-49	78103	18003	16867	13214	9606	8448	7840	1956	1956	213
50-54	66691	15512	14621	10333	8344	7122	7157	1789	1619	194
55-59	47295	10683	10690	7494	6008	4874	5092	1258	1045	151
60-100	82990	17428	19343	13576	9685	8834	9851	2179	1840	254
100+	44	6	8	11	6	6	6	1		
Дүн	1314486	308672	295827	208898	159514	138368	136424	34547	28333	3903

Нийслэл хотын нийт хүн амын 63.6 хувь нь 35 хүртэлх насны залуучууд байна. Тодруулбал, нийт хүн амын 28.2 хувь буюу 370.1 нь 0-15 насны хүүхэд, 65.5 хувь буюу 861.3 нь 16-59 насны хүмүүс, 6.3 хувь буюу 83.0 мянга нь 60 ба түүнээс дээш насны өндөр настан юм.

Зураг 49. Нийслэлийн суурин хүн ам, дүүргээр



Нийслэлийн суурин хүн амын 23.5 хувь буюу 308.7 мянга нь Баянзүрх дүүрэгт, 22.5 хувь буюу 295.8 мянга нь Сонгинохайрхан дүүрэгт, 15.9 хувь буюу 208.9 мянга нь Баянгол дүүрэгт, 12.1 хувь буюу 159.5 мянга нь Чингэлтэй дүүрэгт, 10.5 хувь буюу 138.4 мянга нь Хан-Уул дүүрэгт, 10.4 хувь буюу 136.4 мянга нь Сүхбаатар дүүрэгт, 2.6 хувь буюу 34.5 мянга нь Налайх дүүрэгт, 2.2 хувь буюу 28.3 мянга нь Багануур дүүрэгт, 0.3 хувь буюу 3.9 мянга нь Багахангай дүүрэгт тус тус оршин сууж байна.

НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР